



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

Журам, загвар шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.9 дэх хэсэг, Ахмад настны тухай хуулийн 7.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Магадлан итгэмжлэгдсэн иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад олгох гэрчилгээний загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж, магадлан итгэмжлэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Ундрал/, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/52 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ